



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01.

Улаанбаатар хот

“Сахилга хариуцлага –Хөдөлмөрийн
аюулгүй байдлын жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарын хэмжээнд 2020 оныг “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил” болгон зарласугай.

2. “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбогдуулан Төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох стандарт, дүрэм, журмыг мөрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын хариуцлага, сахилга дэг журмыг чангатгах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг яам, харьяа байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

2.1. Төрийн албаны тухай хуулиар хүлээсэн “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн салбарын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн болон мэргэжлийн байгууллага, ажилтны дүрэм, ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, ажлын хариуцлага, сахилга дэг журмыг мөрдөн сахих ажлын хүрээнд:

2.1.1.албан хаагчид хууль болон гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа бүрэн ухамсарлаж, албан үүргээ хуулийн хүрээнд шударга, хариуцлагатай гүйцэтгэх;

2.1.2.авилгын эсрэг хууль тогтоомжид заасан авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;

2.1.3.албан хаагчдын ажлын гүйцэтгэлд удирдлагаас байнгын хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэж, зохион байгуулж ажиллах;

080005

2.1.4.ажлын байранд болон албан томилолтоор ажиллахдаа согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.1.5.ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг чанд сахиж буйд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцон, ажил дүгнэх үзүүлэлт болгож хэвших;

2.1.6.иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж улирал, хагас жилээр дүн шинжилгээ хийж ажиллах;

2.1.7. төрийн албыг хувийн ашиг сонирхол болгохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

2.1.8.Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажил цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, хууль тогтоомжид заасан тохиолдолд зохих байгууллага албан тушаалтанд мэдээлж ажиллах.

2.2. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах” гэсэн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ажлыг эрчимжүүлж, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд:

2.2.1 Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 253 дугаар тушаалын заалт бүрийг хэрэгжүүлж, биелэлтийг үнэлж дүгнэн, тайлагнаж ажиллах;

2.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох стандарт, дүрэм, журмыг мөрдүүлж, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг улирал тутамд тайлагнаж ажиллах;

2.2.3. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэн ажиллах;

2.2.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд дотоодын үзлэг, шалгалт хийлгэн, үр дүнг байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч байх;

2.2.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөн, сургалтын тусгай хөтөлбөр боловсруулан Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай

хуулийн сэдвээр сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллах;

2.2.6. хариуцсан байгууллагын дотоод нэгжийн ажлыг дүгнэхдээ сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлсэн ажлыг ажил дүгнэх үзүүлэлт болгон дүгнэж хэвших;

2.2.7. Зам, тээврийн салбарын "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо"-ноос шаардлагатай тохиолдолд мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа чиглэл авч ажиллаж байх;

2.2.8. байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтныг томилон ажиллуулах;

2.2.9. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх сургалтын төсвийг жил бүр байгууллагын төсөвт тусган санхүүжүүлэх.

3. Харьяа байгууллагын ажлыг дүгнэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дугаар албан даалгавар, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны "Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дугаар албан даалгаврын болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 253 дугаар тушаалын заалт бүрийг ажил дүгнэх үзүүлэлтэд тооцож, үнэлгээ өгч, албан хаагчдаас холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэхэд нь байнга, тогтмол хяналт тавьж ажиллахыг яамны газрын дарга нарт даалгасугай.


4. Зам, тээврийн салбарын хэмжээнд "Зам, тээврийн хөгжлийн сайдын нэрэмжит хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзлэг"-ийг оны эхний хагас жилд багтаан зохион байгуулахыг Дэд сайд бөгөөд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга /Л.Халтар/-д даалгасугай.

5. Яамны газар хэлтсийн даргын ажлыг дүгнэхдээ хариуцсан салбарын байгууллагын сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнг ажлын нэг үзүүлэлт болгон үнэлж, байхыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/-т үүрэг болгосугай.

6. "Сахилга хариуцлага -Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил"-ийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг баталж, биелэлтийг улирал тутамд Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/-т тайлагнаж ажиллахыг газрын дарга, харьяа байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд бөгөөд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга /Л.Халтар/-д, Төрийн захиргаа, удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН